




ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ

## БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

### БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН



СӨҮЛ ХОТ

2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол Улс, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг, ХНХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж биелэлтийг хангуулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалан ажиллаж байна.

Төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг, Нийгмийн даатгалын тасаг гэсэн 2 тасагтайгаар тайлант хугацаанд ажлын чиг үүрэг, хуваарийн дагуу дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

### **1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД**

- 1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд
- 1.2 БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хүрээнд
- 1.3 Гэрээт ажилчдын ахисан түвшний боловсролыг дэмжих ажлын хүрээнд

### **2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД**

- 2.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох
- 2.2 БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, нийгмийн хамгааллын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох
- 2.3 Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд
- 2.4 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Е-8, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд

### **3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД**

- 3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд
- 3.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд
- 3.3 Сургалт, судалгааны ажлын хүрээнд

### 3.4 Бусад дотоод ажлын хүрээнд

## **1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2023 оны 09 дүгээр сарын 01-нээс 09 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт 266 иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн алба болон ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрхзүйн зөвлөгөө өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын “Самсунг” даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардал, гэнэтийн ослын даатгал, үйлдвэрлэлийн ослын даатгал хэлбэрээр нийт 39,763,540 вон /гучин есөн сая долоон зуун жаран гурван мянга таван зуун дөч/-ыг Монгол Улсын иргэдэд олгууллаа. Тухайлбал, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү 10,756,832 вон, нутаг буцах замын зардал 1,500,000 вон, Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин хэлбэрээр 13,380,000 вон, хууль бусаар ажилладаг иргэдийн авч чадаагүй цалин хөлс 7,846,708 воныг ажил олгогчоос тус тус гаргуулан өргөдөл гаргагчдад олгуулсан.

### **1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд:**

- Төвийн цахим хуудсаар ирж буй өргөдлийг төрөлжүүлэн хүлээн авч, 35 иргэний санал, хүсэлтэд холбогдох зөвлөгөө мэдээллийг өгөв.

### **1.2 БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хүрээнд:**

- Хууль бусаар оршин суугч Э.Н-ын олгогдоогүй цалингийн асуудлаар ажил олгогчтой холбогдон нэхэмжилж 5,580,000 воныг олгуулсан бөгөөд үлдэгдэл цалинг олгуулахаар Сөүлийн Хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн яамны орон нутгийн салбарт өргөдөл гарган ажиллаж байна.

### **1.3 Ахисан түвшнийг дэмжих ажлын хүрээнд**

- Е-9 статусаас Е-7-4 рүү визний ангиллаа солиулж ахисан түвшинд хүрэх хүсэлтэй иргэдийг бүртгэлийн санд оруулж, холбогдох сургалтад бүртгүүлэх, бусад зөвлөгөө мэдээлэл өгч, оноог тооцоолж өгөв.

- Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу шинээр ирэх мэргэжлийн бус ангилалтай E-9 визтэй хөдөлмөрийн гэрээт ажилчдын ажиллах салбарын төрлийг нэмэгдүүлэхээр БНСУ-ын Гадаад ажилчдын бодлого зохицуулалтын хорооноос 2023 оны 09 сарын 07-ны өдөр “Гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль тогтоомж”-ийн 5 дугаар зүйлд заасан шийдвэрийг орчуулж төвийн цахим хуудсанд байршуулав.

## **2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД**

### **2.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд**

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тасаг нь БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн 14 иргэнийг тэтгэврийн даатгалд шинээр хамруулан, гэрээ байгуулж, “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн программ” /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/> мэдээллийн санд бүртгэв.

Иргэд, даатгуулагчдад Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг нийтдээ 41 удаа бичиж олгосон. Үүнд: шинээр 16, гэрээ сунгаж 22, гэрчилгээг гэж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 3 байна.

### **2.2 БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох**

2023 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар сайн дурын даатгалд нийт 977 даатгуулагчийн бүртгэл хийгдэж, холбогдох хувийн хэргийг хөтлөн <https://app.ndaatgal.mn:811/sdkorea/> программд мэдээллийг тогтмол шинэчлэн, хяналт тавьж ажиллав.

Тайлант хугацаанд 21 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулж, гэрээ байгуулсан. БНСУ-ын аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлдэг 21 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов. Мөн 2023 оны 08 дугаар сарын 31-нээр гэрээ дуусгавар болсон даатгуулагчдын гэрээг сунгаж ажиллав.

**2.3 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд**

НДЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 тушаалаар тус тасгийн 2023 оны орлогын төлөвлөгөө 3,347,614,600.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 278,967,883.33 төгрөг болно.

Тус тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 36,470,500.00 вон, сайн дурын даатгалын шимтгэл 50,409,588.00 вон, нийт 86,880,088 вон буюу 228,494,631.44 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 9 дүгээр сарын орлогын төлөвлөгөөг 82 хувийн гүйцэтгэлтэй биелүүлэв.

Түүнчлэн сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчдын мэдээлэл, гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог “https://app.ndaatgal.mn:811/sdkorea/gereelist.aspx” программын мэдээллийн сангаар хянан, төлөлт хийлгэж ажиллалаа. Тайлант хугацаанд шимтгэл төлөхгүй байгаа даатгуулагчид болон ажил олгогчдод шимтгэлийн төлөлт хийхийг сануулан 410 удаа нэхэмжлэл факсаар илгээж, 744 удаа утсаар холбогдов.

*Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын байдлаар харуулбал:*

*/2023.09.30-ны өдрөөр, ханш 2.63/  
Хүснэгт-1*

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого		Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гаригийн хаалтын ханш
		Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
8	278,967,883.33	36,470,500.00	95,917,415.00	50,409,588.00	132,577,216.44	86,880,088.00	228,494,631.44	82	2.63

**2.4. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Е-8, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд**

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 191, 192 дүгээр ээлжийн 8 иргэний материал НДЕГ-аас ирснийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд илгээж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

**3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД**

### **3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд**

- Тайлант хугацаанд Mnb.mn, Gogo.mn, Ikon.mn, News.mn, Vip76.mn, Ontslakh.mn, Zugii.mn, Tusgal.mn, Asuudal.mn, Mpress.mn, Focus.mn, Zaluu.com, 24tsag.mn, Chig.mn, Daam.mn, Erennews.mn зэрэг 16 олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан төвийн үйл ажиллагаа, ХНХ-ын сайд Х.Булгантуяагийн БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны төлөөлөлтэй хийсэн уулзалтын мэдээллийг түгээсэн.
- Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” социал хуудсанд 14 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 13 удаа мэдээлэл, зөвлөгөө нийтэлж БНСУ-д амьдарч буй иргэдийн өргөн ашигладаг социал хуудаснууд /Нүүдэлчин Монголчууд, Дэлхийн Монголчуудын радио-MGLRADIO, Гэрээнийхэн наашаа E-9, Солонгос дахь Монголчуудын нэгдсэн групп, ХХҮЕГ БНСУ-д хөдөлмөрийн гэрээний ажилтан/-д түгээн сурталчлав.
- Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 957, үүнээс 942 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 15 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

### **3.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд**

- Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн менежмент, хөгжлийн сангийн Тамгын газрын дарга Ким Тэ Хуантай албан уулзалт хийсэн ба уулзалтад төвийн дарга Д.Баярмандах, холбогдох мэргэжилтнүүдийн хамт оролцов. Уулзалтаар хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд ажиллах хүч илгээхэд Монгол Улсаас ирэх хөдөлмөрийн гэрээт ажилчдын квотыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөдөлмөрийн салбарын чиглэлийг өргөжүүлэх, олон улсын сургалт семинарыг хамтран зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн бодлого төлөвлөлтийн журам боловсруулах, гурван жилийн хугацаатай хэрэгжүүлдэг ODA төсөлд энэ жил Монгол Улс саналаа өгч хамтран оролцох зэрэг асуудлаар харилцан санал солилцов.
- Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд Б.Бат-Эрдэнэ нар 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр БНСУ-ын Үндэсний Ассамблейд зочилж, “БНСУ дахь гадаад иргэдийн хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн халамж ба тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх нь” хэлэлцүүлэгт оролцсон. БНСУ-ын Үндэсний ассамблейн дэд дарга Ким Ён Жү гишүүний зохион байгуулсан тус хэлэлцүүлэгт төвийн мэргэжилтнүүд орчуулгын үүрэг гүйцэтгэв.

### **3.3 Сургалт, судалгааны ажлын хүрээнд**

- Төвийн хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь илгээгч 16 улс хөдөлмөрийн гэрээт ажилчдаа хууль бус оршин суугч болгохгүйн тулд хэрэгжүүлж буй арга хэмжээг судлан, дээрх орнуудаас хууль бусаар оршин сууж байгаа иргэдийн статистик судалгааг шинэчлэн боловсруулав.
- Нийгмийн даатгалын тасаг нь БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны үйл ажиллагаа, тоон мэдээлэл, сангийн менежмент зэрэг асуудлаар судалгаа мэдээлэл боловсруулав.
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас шаардсан албан хаагчдын судалгаа мэдээллийг загварын дагуу боловсруулан илгээв.

### **3.4 Бусад дотоод ажлын хүрээнд**

- Үндэсний аудитын газраас 2023 оны санхүүгийн болон нийцлийн завсрын аудитыг 09 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд гүйцэтгэсэн ба шаардсан баримт бичиг, материалаар хангаж ажиллав.
- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь процессын дахин инженерчлэлийг салбарт нэвтрүүлэх ажлын хүрээнд 09 дүгээр сарын 01-25-ны өдрийн хооронд тус төвийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж байгаа ба тайлант хугацаанд шаардсан баримт бичиг, судалгаа мэдээллээр хангаж ажиллав.
- Нийгмийн даатгалын тасгийн үйл ажиллагаатай холбоотой Үндэсний аудитын газрын зөвлөмжийн биелэлтийг аудитын цахим программд шивж хариу илгээсэн.
- ХУРДАН төрийн цахим үйлчилгээний системийн операторын горимоор 21 үйлчилгээ, лавлагааг иргэдэд хүргэж ажиллав.
- Нийгмийн даатгалын аппликейшний хэрэглэгчээр 4 иргэний бүртгэлийг баталгаажуулан, код илгээв. Мөн нийгмийн даатгалын лавлагаа мэдээлэл шалгуулах хүсэлт гаргасан 11 даатгуулагчийн хүсэлтийн дагуу мэдээллийг гаргаж, даатгуулагчдад хүргүүлэв.
- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 1 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг Монгол хэл рүү хөрвүүлж үйлчлэв.
- Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн банкин дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гаргаж НДЕГ-т хүргүүлэв.
- Сөүл хотын Жумбугийн цагдаагийн газартай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тараах материалыг тус улсад оршин суугаа Монгол иргэдэд түгээв.
- Байгууллагын веб сайтын Хууль эрх зүйн буланг шинэчилж, 5 хууль, 4 тогтоомж нэмж байршуулав.
- Байгууллагын эрх зүйн мэдээллийн цахим санд шинээр батлагдсан 2 журам, шинэчлэн батлагдсан нийгмийн даатгалын багц хуулийн 4 сургалтын материалыг байршуулж, албан хаагчдад мэдээлэв.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ТАСГИЙН САР ТУТМЫН ТООН МЭДЭЭ**  
*/2023 оны 09 дүгээр сар/*

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	39,763,540 вон
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	266